



**МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХУВЦАС АЛДАРШУУЛАХ “УРАН ҮЙЛ-2023”
ТӨВИЙН БҮСИЙН УРЛААЧДЫН ШИЛДЭГ БҮТЭЭЛ
ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН**

Санаачилагч, Ерөнхий зохион байгуулагч: “Эмэгтэйчүүдийн Дархан Бриллиант клуб” ТББ

Хамтран зохион байгуулагч: Дархан-Уул аймгийн Соёл Урлагийн газар

Дэмжигч байгууллага: УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлангийн ажлын алба, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Залуучууд театр, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Дархан-Уул аймаг дахь танхим, Дархан-Уул аймгийн Ажил Олгогч Эздийн Холбоо, “Дархан Нэхий” ХК, “Дархан Минж” ХХК, “Дархан савхи” ХХК

Зорилго: Соёлын тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 314 дүгээр тогтоол, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний 5.3, 5.4, Соёлын бүтээлч сарын “Бүтээлч байдал, мэдлэг туршлага” арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах хүрээнд Төвийн бүсийн Монгол Үндэсний хувцас урлаачдын ур чадварыг сорих, тэдний бүтээлийг алдаршуулах, урам зоригийг нэмэгдүүлэх, туршлага солилцох, харилцан суралцахын зэрэгцээ **Дарханы брэнд бүтээл** төрүүлэхэд оршино.

Энэхүү уралдааныг 2 жил тутамд уламжлал болгон зохион байгуулж улмаар төвийн бүсийн хэмжээнд төдийгүй бүс тус бүрд, цаашид улсын хэмжээний уралдаан болгон зохион байгуулна.

Хамрах хүрээ: Төвийн бүсийн /Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Орхон, Булган, Хөвсгөл/ аймгуудын Монгол үндэсний хувцас урлаачид, ЕБС болон МСҮТ-ийн дизайн технологийн багш, сурагч, оюутнууд

Зохион байгуулах хугацаа: 2023 оны 11 дүгээр сарын 18, 19-ний өдөр

Уралдаан зохион байгуулах байршил: Залуучууд театр, Дархан сумын 5 дугаар баг, Орос клуб

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү уралдаанд төвийн бүсийн аймгуудад ажиллаж амьдарч буй Монгол үндэсний хувцас урлаачид, ЕБС-ийн технологийн багш, сурагчид нээлттэй оролцох боломжтой.

1.2. Уралдаанд оролцогчдын бүтээл нь 100 хувь тухайн урлаачийн бүтээл байх бөгөөд аливаа бүтээлийн санааг бүтнээр болон хэсэгчилэн хуулбарлахыг хориглоно.

1.3. Уралдаанд оролцох төрлүүд:

- Уламжлалт дээл – 1
- Гоёлын дээл – 1
- Чөлөөт загварын дээл – 2

1.4. Бүтээлд тавигдах шаардлага: Энэхүү уралдаан нь Дархан хотын брэнд бүтээл төрүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулагдаж буй тул урлаачийн аль нэг бүтээлд Дархан хотын онцлог, өнгө төрх, шинж агуулгыг багтаасан байна.

Нийт бүтээлүүдэд тавигдах шаардлага:

- Дизайны уран сайхны шийдэл
- Шинэлэг байдал
- Өнгөний зохицол
- Материалын сонголт
- Бүтээлийн хүний биед суух, тохирох байдал

Хоёр. Уралдааны бүртгэл

2.1. Уралдаанд оролцогчдыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 18:00 цаг хүртэл цахимаар нээлттэй бүртгэнэ.

2.2 Уралдаанд оролцогчид дараах мэдээллүүдийг заасан хугацаанд багтаан “Эмэгтэйчүүдийн Дархан Бриллиант клуб ТББ” фэйсбүүк хаягаар илгээнэ. Үүнд:

- Овог нэр, регистр
- Аймгийн нэр
- Оёдлын чиглэлээр ажилласан жил, туршлага
- Оёдлын чиглэлээр өмнө оролцож байсан уралдаан тэмцээний шагнал урамшуулал
- Холбогдох утасны дугаар,
- Цахим хаяг
- Бүртгэлийн хураамж төлсөн баримтын хуулбар

2.3. Уралдаанд оролцогчийн хураамж 100,000₮ /нэг зуун мянган төгрөг/ байх бөгөөд хураамжийг **Хаанбанк 5046215848 – М.Оюунбаяр** дансанд өөрийн нэр, аймаг, утасны дугаарыг бичиж шилжүүлэн, хуулгыг “Эмэгтэйчүүдийн Дархан Бриллиант клуб ТББ” фэйсбүүк хаягаар илгээн бүртгэлээ баталгаажуулна.

2.4. Уралдаанд оролцохоор бүртгүүлсэн хураамжийг буцаан олгохгүй.

Гурав. Шалгаруулалт

3.1. Уралдааны шалгаруулалт 2 үе шаттай явагдана.

- I шат – Уралдаанд оролцогчдын нийт бүтээлийг үзэгч, шүүгчдэд дэлгэн үзүүлж үндсэн шаардлагын дагуу үнэлнэ.
- II шат - Шүүгчдийн эхний шатны үнэлгээгээр II шатанд шалгарсан шилдэг бүтээлүүдийг урлаач, дизайнерийн өгүүлэмж санаа, бүтээлд шингэсэн онцлог, шинэлэг санааг тайлбарласны үр дүнд эцсийн үнэлгээг өгнө.

3.2. Уралдааныг мэргэжлийн шүүгчид бүтээлийн төрөл тус бүрд заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу оноо өгч бүтээлд тавигдах шаардлагыг харгалзан 1 урлаачийн 4 бүтээлийн нийлбэр онооны дүнгээр байр эзлүүлнэ.

Дөрөв. Шагнал урамшуулал:

4.1. Үзэсгэлэн худалдаа:

- Шилдэг борлуулалттай бүтээл – 1 – 300,000₮
- Үлгэр жишээ оролцогч – 1 – 300,000₮

4.2. Уралдаан:

- I байр - 1 - цом, өргөмжлөл 2,000,000 төгрөг
- II байр - 1 - цом, өргөмжлөл 1,000,000 төгрөг
- III байр - 1 - цом, өргөмжлөл 500,000 төгрөг
- Үзэгчдийн таашаалд нийцсэн бүтээл - 1 - цом, өргөмжлөл, Аяллын эрхийн бичиг
- “Бриллиант клуб”-ын нэрэмжит бүтээл – 1 - цом, өргөмжлөл, Үнэ бүхий зүйл

Нийт оролцогчдод БАТЛАМЖ гардуулна.

Тав: Бусад

5.1. Урлаачид өөрсдийн бүтээлийг өмсөх загвар өмсөгчдийг өөрсдөө авч ирэх бөгөөд загвар өмсөгч нь 18 буюу түүнээс дээш настай насанд хүрсэн иргэн байна.

5.2. Уралдаанд оролцож буй урлаачид 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр 10:00-17:00 цагт Залуучууд театрын 1 дүгээр давхарт зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаанд өөрсдийн бүтээлээрээ оролцох боломжтой.

5.3. Мөн тус өдрийн 14:00 цагт Залуучууд театрын 2 дугаар давхарт зохион байгуулагдах Хувцас урлах аргыг түгээн дэлгэрүүлэх сургалт, уулзалтад хамрагдана.

Зургаа: Холбоо барих болон дэлгэрэнгүй мэдээлэл авах

Facebook хаяг: “Эмэгтэйчүүдийн Дархан Бриллиант клуб” ТББ
Харилцах утас: 8601-4646/Тэргүүн Б.Батцэцэг/, 8057-2277 /Нарийн бичгийн дарга Ц.Бүжин/, 9965-8109/Соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн Б.Чинбилэг/